



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД

МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70512121, 70518232

2024.05.08 № 01/576

танай _____ -ны № _____ -т

Хүсэлт хүргүүлэх тухай

“10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”-ийн хүрээнд Баруун-Урт суманд баригдаж буй дулааны станцын гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын зардал нь 2024 оны Улсын төсөвт “XVII.1.26 Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Сүхбаатар, Баруун-Урт сум/” нэртэйгээр 5,913.3 сая төгрөг батлагдсан билээ. Уг ажлын хүрээнд дараах ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөн.

- “110/35/10 кВ-ын Баруун-Урт дэд станцын өргөтгөлийн ажил”-ын магадлалаар баталгаажсан барилга угсралтын хяналтын төсөв нь 4,379.48 сая төгрөг.
- “Дулааны станцын гадна ус хангамж, ариутгах татуургын ажил”-ын барилга угсралтын хяналтын төсөв нь 39.98 сая төгрөг.
- “Дулааны станцын гадна холбооны шугам сүлжээний ажил”-ын барилга угсралтын хяналтын төсөв нь 38.71 сая төгрөг

Нийтдээ 4,458.17 сая төгрөгийн ажил хийгдэхээр байгаа бөгөөд Улсын төсөвт батлагдсан зардлаас 1,455.13 төгрөг хэмнэгдэхээр байна.

Иймд хэмнэлтээр “2013 онд ашиглалтад орсон Баруун-Урт сумын дулааны 1-р хэлхээний төв магистрал шугамын Dx103-104 цэгийн хоорондох 400мм голчтой 120 м хос шугам нь Баруун Уртын гол доогуур байнгын хөрсний усанд олон жил болсон тул гэмтэл гарах магадлал өндөр байгаа бөгөөд уг шугамыг ил болгох ажил (төсөвт өртөг нь 635,56 сая төгрөг)-ыг гүйцэтгүүлэх, арга хэмжээг зохион байгуулж өгөхийг хүсье.

ЗАСАГ ДАРГА

М.ИДЭРБАТ



2204750242